



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ХӨГЖЛИЙН  
ТӨВИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/235/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Сэржмядаг  
Утас: 261628 Цахим хаяг: [serjmyadagb@audit.gov.mn](mailto:serjmyadagb@audit.gov.mn)  
Аудитор: Н.Баттөгөлдөр  
Утас: 261628 Цахим хаяг: [battuguldum@audit.gov.mn](mailto:battuguldum@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Амгалан Ахуй Аудит" ХХК  
Захирал Д.Амгалан  
Цахим хаяг: [amgalanahui.audit@gmail.com](mailto:amgalanahui.audit@gmail.com)

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

---

1. Аудитын гэрчилгээ .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	15
3.4 Материаллаг байдал .....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал .....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт .....	20
4.1 Залруулсан алдаа .....	20
4.2 Албан шаардлага .....	20
4.3 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	22

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХБХСЗХТ	Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдийн Сэргээн Засах Хөгжлийн Төв
ЭМДС	Эрүүл Мэндийн Даатгалын Сан



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН  
СЭРГЭЭН ЗАСАХ ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ П.ХИШИГЖАРГАЛ ТАНАА

2022.02.23 № 07/243  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,179,519,461.09	1,758,176,223.80
33	АВЛАГА	-	3,563,500.00
335	Бусад авлага	-	3,563,500.00
3351	Байгууллагаас авах авлага	-	3,563,500.00
34	УРЬДЧИЛГАА	72,702,472.80	-
34600	Урьдчилж гарсан зардал	72,702,472.80	-
35	БАРАА МАТЕРИАЛ	1,106,816,988.29	1,754,612,723.80
351	Түүхий эд материал	334,079,913.83	241,718,139.86
35110	Тусгай зориулалттай материал	41,448,528.00	34,616,938.00
35130	Эм боох материал	292,631,385.83	207,101,201.86
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	-	1,655,830.70
354	Хангамжийн материал	772,737,074.46	1,511,238,753.24
35410	Бичиг хэргийн материал	24,529,034.70	3,115,846.70
35420	Аж ахуйн материал	14,771,165.06	6,159,906.08
35440	Түлш шатах тослох материал	843,213.00	1,398,489.48
35460	Хүнсний материал	43,495,891.00	36,252,195.05
35470	Бусад хангамжийн материал	689,097,770.70	1,464,312,315.93
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,587,540,001.20</b>	<b>7,850,460,204.28</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>6,587,540,001.20</b>	<b>7,850,460,204.28</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>5,658,620,978.79</b>	<b>7,066,321,450.87</b>
39205	Машин, тоног төхөөрөмж	5,343,745,115.30	7,612,560,510.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	(533,184,223.74)	(1,416,343,035.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	941,960,884.37	1,072,117,107.41
39208	Хуримтлагдсан элэгдэл	(93,900,797.14)	(202,013,131.87)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>928,919,022.41</b>	<b>784,138,753.41</b>
39301	Програм хангамж	665,921,076.36	687,621,076.36
39302	Хасагдуулга	(31,297,803.95)	(197,778,072.95)
39303	Бусад биет бус хөрөнгө	294,295,750.00	294,295,750.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7,767,059,462.29</b>	<b>9,608,636,428.08</b>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	7,767,059,462.29	9,608,636,428.08
51	Засгийн газрын хувь оролцоо	7,767,059,462.29	9,608,636,428.08
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	294,295,750.00	294,295,750.00
51101	Өмч: -Төрийн өмч	294,295,750.00	294,295,750.00
512	Хуримтлагдсан үр дүн	7,472,763,712.29	9,314,340,678.08
51210	Өмнөх үеийн үр дүн	665,732,766.86	7,472,763,712.29
51220	Тайлант үеийн үр дүн	6,807,030,945.43	1,841,576,965.79
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	7,767,059,462.29	9,608,636,428.08



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>11,720,319,699.16</b>	<b>8,181,286,490.24</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,248,923,299.16</b>	<b>3,321,499,290.24</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>7,248,923,299.16</b>	<b>3,321,499,290.24</b>
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	7,248,923,299.16	3,321,499,290.24
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42,346,074.42	43,435,937.59
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,206,577,224.74	3,278,063,352.65
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,471,396,400.00</b>	<b>4,859,787,200.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,294,335,000.00	4,036,082,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,294,335,000.00	4,036,082,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>177,061,400.00</b>	<b>823,704,400.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	177,061,400.00	6,634,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	817,070,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>4,913,288,753.73</b>	<b>6,339,709,524.45</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,913,288,753.73</b>	<b>6,339,709,524.45</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,986,564,021.36</b>	<b>4,710,344,519.86</b>
<b>2101</b>	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,283,853,315.74</b>	<b>2,402,470,690.36</b>
210101	Цалин	2,282,189,408.17	2,401,023,536.80
210102	Нэмэгдэл цалин	1,663,907.57	1,447,153.56
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>280,097,297.75</b>	<b>312,514,635.18</b>
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	195,000,125.30	220,938,293.16
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	22,941,191.21	24,746,103.60
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	18,168,152.97	19,299,603.48
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	3,988,348.02	4,307,602.90
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	39,999,480.24	43,223,032.04
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>121,506,577.59</b>	<b>164,787,786.95</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	79,994,498.68	80,353,326.09
210302	Түлш, халаалтын зардал	35,312,027.91	76,902,977.86
210303	Цэвэр, бохир усны зардал	6,200,051.00	7,531,483.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>101,396,614.88</b>	<b>81,910,206.54</b>
210401	Бичиг хэргийн материал	9,993,030.30	8,902,329.00
210402	Тээвэр, шатахууны зардал	9,590,980.00	11,355,134.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	7,905,883.64	8,614,071.51
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	32,318,377.22	26,894,506.89
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	41,588,343.72	26,144,165.14
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>461,320,588.57</b>	<b>545,741,703.59</b>
210501	Эм	172,661,595.96	329,676,770.83
210502	Хоол	238,948,693.61	162,132,389.76
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,710,299.00	53,932,543.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,514,600.00</b>	<b>9,822,911.00</b>
210601	Багаж хэрэгсэл	156,600.00	3,318,471.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	584,850.00	6,504,440.00
210604	Урсгал засвар	4,773,150.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>400,000.00</b>	<b>-</b>
210702	Дотоод томилолтын зардал	400,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>67,949,820.00</b>	<b>33,170,237.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,901,300.00	6,625,755.00

210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,300,000.00	4,600,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	605,246.00	187,110.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,668.00	56,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	33,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	935,000.00	1,144,000.00
210807	Газрын төлбөр	2,719,000.00	2,509,800.00
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	30,250,606.00	18,014,572.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>664,525,206.83</b>	<b>1,159,926,349.24</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	172,500.00	244,050.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	5,969,882.00	1,930,884.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	658,382,824.83	1,157,751,415.24
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>926,724,732.37</b>	<b>1,629,365,004.59</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	<b>2,276,779.00</b>	<b>50,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	2,276,779.00	50,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	<b>924,447,953.37</b>	<b>1,579,365,004.59</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	924,447,953.37	1,579,365,004.59
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>6,807,030,945.43</b>	<b>1,841,576,965.79</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)</b>	<b>6,807,030,945.43</b>	<b>1,841,576,965.79</b>



### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	<b>294,295,750.00</b>	<b>665,732,766.86</b>	<b>960,028,516.86</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>294,295,750.00</b>	<b>665,732,766.86</b>	<b>960,028,516.86</b>
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.00	6,807,030,945.43	6,807,030,945.43
<b>2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>294,295,750.00</b>	<b>7,472,763,712.29</b>	<b>7,767,059,462.29</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>294,295,750.00</b>	<b>7,472,763,712.29</b>	<b>7,767,059,462.29</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.00	1,841,576,965.79	1,841,576,965.79
<b>2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>294,295,750.00</b>	<b>9,314,340,678.08</b>	<b>9,608,636,428.08</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,496,144,209.00</b>	<b>4,875,826,400.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>24,747,809.00</b>	<b>19,602,700.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>24,747,809.00</b>	<b>19,602,700.00</b>
120004	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>24,747,809.00</b>	<b>19,602,700.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,747,809.00	19,602,700.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,471,396,400.00</b>	<b>4,856,223,700.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>4,294,335,000.00</b>	<b>4,036,082,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,294,335,000.00	4,036,082,800.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>177,061,400.00</b>	<b>820,140,900.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	177,061,400.00	6,634,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	813,506,500.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>4,439,335,909.00</b>	<b>4,865,661,800.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,439,335,909.00</b>	<b>4,865,661,800.00</b>
210	<b>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,512,611,176.98</b>	<b>3,236,296,795.41</b>
2101	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,239,719,952.32</b>	<b>2,401,836,087.95</b>
210101	Үндсэн цалин	1,304,788,399.32	1,658,200,296.81
210102	Нэмэгдэл	772,624,796.06	645,496,574.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	162,306,756.94	98,139,216.73
2102	<b>Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>306,632,396.10</b>	<b>289,316,000.00</b>
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	193,933,599.82	224,768,300.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	28,181,438.93	16,137,100.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	22,545,151.52	12,909,400.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	5,633,845.55	3,227,700.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	56,338,360.28	32,273,500.00
2103	<b>Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал</b>	<b>122,314,417.59</b>	<b>164,787,786.95</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	80,802,338.68	80,353,326.09
210302	Түлш, халаалтын зардал	35,312,027.91	76,902,977.86
210303	Цэвэр, бохир усны зардал	6,200,051.00	7,531,483.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>171,726,154.64</b>	<b>110,945,361.51</b>
210401	Бичиг хэрэг	7,740,256.00	5,786,465.00
210402	Тээвэр, шатахуун	9,900,000.00	10,617,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,905,883.64	8,614,071.51
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	36,166,271.00	29,940,020.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	110,013,744.00	55,986,905.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>573,756,810.33</b>	<b>207,546,798.00</b>
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	305,431,368.33	110,887,538.00
210502	Хоол, хүнс	174,017,853.00	96,659,260.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	94,307,589.00	-
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>15,122,015.00</b>	<b>29,328,131.00</b>
210601	Багаж техник хэрэгсэл	7,941,300.00	14,962,831.00
210603	Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	2,959,265.00	12,923,800.00
210604	Урсгал засвар	4,221,450.00	1,441,500.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>400,000.00</b>	-
210702	Дотоод албан томилолт	400,000.00	-
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>78,676,260.00</b>	<b>25,139,540.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	31,638,300.00	16,609,630.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,300,000.00	4,600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	605,246.00	187,110.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,668.00	56,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	33,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	935,000.00	1,144,000.00
210807	Газрын төлбөр	2,719,000.00	2,509,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	40,240,046.00	-
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,263,171.00</b>	<b>7,397,090.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	284,500.00	244,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	3,978,671.00	7,153,040.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>926,724,732.02</b>	<b>1,629,365,004.59</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,276,779.00</b>	<b>50,000,000.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	0.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	2,276,779.00	50,000,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>924,447,953.02</b>	<b>1,579,365,004.59</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	924,447,953.02	1,579,365,004.59
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>56,808,300.00</b>	<b>10,164,600.00</b>
4	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>56,808,300.00</b>	<b>10,164,600.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>56,808,300.00</b>	<b>10,164,600.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	56,808,300.00	10,164,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	56,808,300.00	10,164,600.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(56,808,300.00)</b>	<b>(10,164,600.00)</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	<b>0.00</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<b>0.00</b>	<b>0.00</b>
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	<b>0.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн
<b>2</b>	<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,046,082,800.00</b>	<b>2,548,359,404.90</b>	<b>1,497,723,395.10</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,046,082,800.00</b>	<b>2,548,359,404.90</b>	<b>1,497,723,395.10</b>
<b>210</b>	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>4,041,894,800.00</b>	<b>2,547,359,404.90</b>	<b>1,494,535,395.10</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,660,298,100.00	1,867,967,380.14	792,330,719.86
210101	Үндсэн цалин	1,485,646,500.00	1,124,331,589.00	361,314,911.00
210102	Нэмэгдэл	1,016,568,600.00	645,496,574.41	371,072,025.59
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	158,083,000.00	98,139,216.73	59,943,783.27
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>361,425,300.00</b>	<b>217,847,000.00</b>	<b>143,578,300.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	250,773,300.00	153,299,300.00	97,474,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	27,663,000.00	16,137,100.00	11,525,900.00
210203	ҮОМШӨ ний даатгал	22,130,400.00	12,909,400.00	9,221,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,532,600.00	3,227,700.00	2,304,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	55,326,000.00	32,273,500.00	23,052,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>202,765,700.00</b>	<b>164,787,786.95</b>	<b>37,977,913.05</b>
210301	Гэрэл цахилгаан	90,528,400.00	80,353,326.09	10,175,073.91
210302	Түлш, халаалт	89,022,200.00	76,902,977.86	12,119,222.14
210303	Цэвэр, бохир ус	23,215,100.00	7,531,483.00	15,683,617.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>119,318,300.00</b>	<b>74,783,417.81</b>	<b>44,534,882.19</b>
210401	Бичиг хэрэг	7,498,200.00	5,786,465.00	1,711,735.00
210402	Тээвэр (шатахуун)	10,003,000.00	7,617,900.00	2,385,100.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	9,627,200.00	6,619,987.81	3,007,212.19
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	46,889,600.00	29,940,020.00	16,949,580.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	45,300,300.00	24,819,045.00	20,481,255.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>584,512,900.00</b>	<b>177,214,790.00</b>	<b>407,298,110.00</b>
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	350,062,600.00	97,555,530.00	252,507,070.00
210502	Хоол, хүнс	234,450,300.00	79,659,260.00	154,791,040.00
<b>2106</b>	<b>Эд хогшил худалдан авах</b>	<b>27,599,300.00</b>	<b>14,443,400.00</b>	<b>13,155,900.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,881,600.00	78,100.00	1,803,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	22,002,500.00	12,923,800.00	9,078,700.00
210604	Урсгал засвар	3,715,200.00	1,441,500.00	2,273,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>836,300.00</b>	-	<b>836,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	836,300.00	-	836,300.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>81,659,300.00</b>	<b>28,569,540.00</b>	<b>53,089,760.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,073,000.00	20,039,630.00	4,033,370.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	13,931,600.00	4,600,000.00	9,331,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	881,100.00	187,110.00	693,990.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	298,800.00	56,000.00	242,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	198,000.00	33,000.00	165,000.00
210806	Мэдээллийн технологийн зардал	1,700,000.00	1,144,000.00	556,000.00
210807	Газрын төлбөр	2,509,800.00	2,509,800.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	38,067,000.00	-	38,067,000.00
<b>2201</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,479,600.00</b>	<b>1,746,090.00</b>	<b>1,733,510.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,498,600.00	244,050.00	1,254,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,981,000.00	1,502,040.00	478,960.00
	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,188,000.00</b>	<b>1,000,000.00</b>	<b>3,188,000.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,188,000.00	1,000,000.00	3,188,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	4,188,000.00	1,000,000.00	3,188,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,046,082,800.00</b>	<b>2,548,359,404.90</b>	<b>1,497,723,395.10</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>4,036,082,800.00</b>	<b>2,528,756,704.90</b>	<b>1,507,326,095.10</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,036,082,800.00	2,528,756,704.90	1,507,326,095.10
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,000,000.00	19,602,700.00	(9,602,700.00)
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	19,602,700.00	(9,602,700.00)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	189.00	175.00	14.00
620001	Удирдах ажилтан	9.00	9.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	140.00	126.00	14.00
620003	Үйлчлэх ажилтан	40.00	40.00	-
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>820,140,900.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	-	<b>820,140,900.00</b>
<b>210</b>	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	-	<b>699,101,990.51</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	<b>533,868,707.81</b>
210101	Үндсэн цалин	-	533,868,707.81
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	<b>71,469,000.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	-	71,469,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	<b>36,161,943.70</b>
210402	Тээвэр (шатахуун)	-	3,000,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	-	1,994,083.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	-	31,167,860.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	<b>30,332,008.00</b>
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	-	13,332,008.00
210502	Хоол, хүнс	-	17,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил худалдан авах</b>	-	<b>21,619,331.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	21,619,331.00
<b>2201</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>5,651,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	5,651,000.00
	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>121,038,909.49</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	<b>49,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	49,000,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>72,038,909.49</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	72,038,909.49
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>820,140,900.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>820,140,900.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	6,634,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	813,506,500.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>0.00</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	<b>0.00</b>

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 15-ны хооронд Амгалан ахуй аудит ХХК-ийн захирал Д.Амгалан, аудитор Б.Даваацэрэн нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтыг менежер Д.Оюун хэрэгжүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 1/14 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэлхийн жишигт хүрсэн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлэх чиг үүрэг бүхий эмнэлгийн тусламж, үйлчилгээ, боловсролын тусламж, үйлчилгээ, протез, ортопедийн хэрэгслийн үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Засгийн газрын 2021 оны 382 дүгээр тогтоол “Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа төрийн үйлчилгээний зарим албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журам”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналдаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй, Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг мөрдсөн байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт туслах үйл ажиллагааны орлого, зардлын бүртгэлийн талаар тусгаж шинэчилсэн байна.



Хөдөлмөр нийгэм хамгааллын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар Коронавируст (Ковид-19) цар тахлын улмаас 2021 оны санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардлаас 4,913,288.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 49,132.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянахад 2021 оны үр дүнгийн тайлангийн тоон үзүүлэлт өмнөх оноос материаллаг зөрүүтэй өссөн тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 6,343,139.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 63,431.4 мянган төгрөгөөр тогтоолоо.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,841,576.9 мянган төгрөгөөр буюу 23.7 хувиар өсөж, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага		3,563.5	3,563.5
Урьдчилж гарсан тооцоо	72,702.5		(72,702.5)
Бараа материал	1,106,817.0	1,754,612.7	647,795.7
Үндсэн хөрөнгө	6,587,540.0	7,850,460.2	1,262,920.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>7,767,059.5</b>	<b>9,608,636.4</b>	<b>1,841,576.9</b>

Төрийн өмч	294,295.8	294,295.8	-
Хуримтлагдсан үр дүн	7,472,763.7	9,314,340.6	1,841,576.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>7,767,059.5</b>	<b>9,608,636.4</b>	<b>1,841,576.9</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Урьдчилж гарсан зардал данс өмнөх оны үлдэгдэл 72,702.5 мянган төгрөгөөр буурсан;
- Бараа материалын данс БНХАУ-ын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 724,273.5 мянган, дотоод хандив 142,003.2 мянган, урсгал төсвийн худалдан авалт 190,528.0 мянган, нийт 1,056,804.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, 647,795.7 мянган төгрөгөөр өссөн;
- Үндсэн хөрөнгө данс төгрөгийн БНХАУ-ын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 2,358,420.6 мянган, дотоод хандиваар 33,816.4 мянган, төсвийн хөрөнгөөр 6,734.6 мянган, нийт 2,398,971.6 мянган төгрөгөөр нэмэгдэж 1,262,920.2 мянган төгрөгөөр өссөн.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 5,640,120.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 5,640,120.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,330,822.0 мянган төгрөгөөр бууруулж 4,309,298.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор зардлын санхүүжилтийн эх үүсвэрийг 273,215.3 мянган төгрөгөөр бууруулан 4,036,082.8 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгааллын 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээнд нийт 4,036,082.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,036,082.8 мянган, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 10,000.0 мянган, нийт 4,046,082.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,528,756.7 мянган төгрөгийг зарцуулж, 1,517,326.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70206	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгаалал	4,046,082.8	2,548,359.4	(1,497,723.4)	63.0%
1.1	80101	Үйл ажиллагааны зардал	4,041,894.8	2,547,359.4	(1,494,535.4)	63.0%
1.2	80802	Ажил олгогчоос олох тэтгэмж урамшуулал	4,188.0	1,000.0	(3,188.0)	23.9%

Цалин, урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 935,909.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал зардлыг 37,977.9 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал зардлыг 44,534.9 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 407,298.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 53,089.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулж, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,548,359.4 мянган төгрөг буюу 63 хувьтай байна.

Энэ нь Дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын улмаас ковидын хэвтэн эмчлүүлэгчийн тасаг нээж Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 67/A/268 тоот тушаалаар зардлын ЭМДС-аас санхүүжүүлж, эмчлүүлэгч хүүхдийн тоо буурч үндсэн үйл ажиллагаагаа хэвийн явагдаагүй батлагдсан төсвийг 1,579,365.0 мянган төгрөг дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 6,634.4 мянга төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 813,506.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Үүнээс цалин, урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 605,337.7 мянган, хангамж, бараа материалд 36,161.9 мянган, нормативт зардалд 30,332.0 мянган, эд хогшил худалдан авах зардалд 21,619.3 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 5,651.0 мянган, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 49,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, үлдэгдэл 72,038.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 3,563.5 мянган төгрөгийг ЭМДС-аас авах авлагаар бүртгэсэн байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 2 арга хэмжээний хэрэгжилт 91 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 63.0 хувийн биелэлттэй буюу 2,548,359.4 мянган төгрөг байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын эмчилгээний зардалд ЭМДС-аас авах 817,070.0 мянган төгрөгийн санхүүжилт авч давхардсан тоогоор 238 ажилтанд 216,473.1 мянган төгрөгийг ковидын үед ажилласан урамшуулал цалин олгосон байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллага 2019 оны 6 дугаар сарын 1-нд үйл ажиллагаа явуулж эмнэлгийн зориулалтаар ашиглаж байгаа 14,990 кв м БНХАУ-ын буцалтгүй тусламжийн барилгыг Улсын комисс хүлээн аваагүйгээс шалтгаалан данс бүртгэл тусгаагүй байна

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн даргын 2021 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн А/28 тоот тушаалаар туслах үйл ажиллагааны орлого, зардлын бүртгэлийн талаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгаж нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитын явцад шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс худалдан авах ажиллагааны төлөвлөгөө хугацаа хоцроож байршуулсан, өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай нийцээгүй эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан дотоод, хяналт үнэлгээний ажилтанд хариуцлага тооцох шаардлага өгөх.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь протез, ортопед, тусгай хэрэгслийн үйлдвэрлэл явуулдаг бөгөөд туслах үйл ажиллагаанаас өөр үйл ажиллагаа явуулаагүй тохиолдолд тогтмол зардлаас алдагдал учирвал түүнийг нөхөх төсвийн бус эх үүсвэрийг төлөвлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 44-р зүйлд “туслах үйл ажиллагааны зардалд тухайн үйл ажиллагааг эрхлэхтэй холбогдсон шууд болон шууд бус бүх төрлийн зардал, өглөг, санхүүгийн үүргийг оруулж тооцно”, “үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно”, “туслах үйл ажиллагаанаас алдагдал учирвал түүнийг нөхөх төсвийн бус эх үүсвэрийг төлөвлөсөн байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газраас жил болгон сонгон шалгаруулалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст халамжийн сангаар дамжуулан олгодог тусламж үйлчилгээ олгох эрхийг тасралтгүй авч үйл ажиллагааг явуулж, алдагдалгүй байхад анхаарч ажиллах зөвлөмж өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай, төсвийн төлөвлөлт нь Төсвийн тухай хуулийн 44.1.2-т “туслах үйл ажиллагаанаас алдагдал учирвал түүнийг нөхөх төсвийн бус эх үүсвэрийг төлөвлөсөн байх” гэсэн заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 38,629.2 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илрүүлснээс аудитын явцад залруулсан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудсанд 44 мэдээг хугацаа хоцроож, 6 мэдээг байршуулаагүй зөрчил, бусад албан шаардлагын биелэлт 95

хувь, 34,796.5 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь, нийт 97.5 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	71,702.5	1	71,702.5	1	-	95
Зөвлөмж	5	34,796.5	5	34,796.5	-	-	100
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>106,499.0</b>	<b>6</b>	<b>106,499.0</b>	<b>1</b>		<b>97.5</b>

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн туслах хэрэгсэл, хэрэглэгдэхүүнээр хангах үйлдвэрлэх газрын материал үйлдвэрлэл өртөг тооцоолол бүртгэлийг хянах асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 105,725.8 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 64,620.4 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 28,518.8 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 12,586.6 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 41,105.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь материаллаг байдлын түвшин 63,431.4 мянган төгрөгөөс бага тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн элэгдлийг 38,629.2 мянган төгрөгөөр дутуу тооцсон;
- 727.7 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллын дагуу бүртгээгүй, бүлэг хооронд шилжүүлэн тайлагнасан;
- Хандиваар авсан мэдээллийн цахим хуудасны 21,700.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг бүртгээгүй;
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас авах санхүүжилтийн үлдэгдэл 3,563.5 мянган төгрөгийг авлагаар бүртгээгүй.

##### 4.2 Албан шаардлага

ЭМДС-аас олгосон Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын дэгдэлтийн үед үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн санхүүжилтийг 28,518.8 мянган төгрөгөөр илүү зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй мөн санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, урсгал зардлаас эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд зарцуулахгүй байх албан шаардлага өгөх.

##### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

###### 1. Мөнгөн кассын ажиллагаатай холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

Цайны газрын үйл ажиллагааны орлого 9,156.6 мянган төгрөгийг байгууллагын харилцах дансанд тушаагаагүй.

Энэ нь Сангийн сайдын 276 дугаар тушаалаар баталсан "Мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 3.12-д заасан “Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын тооцоог гаргаж тайланг тушаана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй.

###### Өгсөн зөвлөмж:

Кассын үйл ажиллагаанд Сангийн сайдын 276 дугаар тушаалаар баталсан журмыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

###### 2. Төсвийн зарцуулалт холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

Тус төв нь үйл ажиллагаандаа зориулж [www.rdccd.mn](http://www.rdccd.mn) цахим хуудсыг 18,270.0 мянган төгрөгийн хандиваар, 3,430.0 мянган төгрөгийг төсвөөс зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 43-р тогтоолын 1.7-д "Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, хууль, тухайн жилийн тогтоомжийг хэрэгжилтийг ханган ажиллаж төсвийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, төсвийн зарцуулалтад хяналт тавих зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д / Д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс										
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
					тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																	
1	ХБХСЗХТ	АХГ-2022/235/НА-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгийн элэгдлийг 38,629.2 мянган төгрөгөөр дутуу тооцсон	Элэгдэл тооцож залруулсан, цаашид алдааг давтан гаргахгүй байх	1	38,629.2	1	38,629.2									
2	ХБХСЗХТ	АХГ-2022/235/НА-СТА-ТШЗ	727.7 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллын дагуу бүртгээгүй, бүлэг хооронд шилжүүлэн тайлагнасан	Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөх, зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй ажиллах	1	727.7	1	727.7									
3	ХБХСЗХТ	АХГ-2022/235/НА-СТА-ТШЗ	Хандиваар авсан мэдээллийн цахим хуудасны 21,700.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг бүртгээгүй	Биет бус хөрөнгийг бүртгэж залруулсан, НББ тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах	1	21,700.0	1	21,700.0									
4	ХБХСЗХТ	АХГ-2022/235/НА-СТА-ТШЗ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас авах санхүүжилтийн үлдэгдэл 3,563.5 мянган төгрөгийг	Авлагыг бүртгэж залруулсан, НББ тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах	1	3,563.5	1	3,563.5									

			авлагаар бүртгээгүй													
5	ХБХСЗХТ	АХГ-2022/235/НА-СТА-ТШЗ	Цайны газрын үйл ажиллагааны орлого 9,156.6 мянган төгрөгийг байгууллагын харилцах дансанд тушаагаагүй	Кассын үйл ажиллагаанд Сангийн сайдын 276 дугаар тушаалаар баталсан журмыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	9,156.6									1	9,156.6
7	ХБХСЗХТ	АХГ-2022/235/НА-СТА-ТШЗ	Тус төв нь үйл ажиллагаандаа зориулж www.rdcdd.mn цахим хуудсыг 18,270.0 мянган төгрөгийн хандиваар, 3,430.0 мянган төгрөгийг төсвөөс зарцуулсан байна	Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, тэвчиж болох зардлыг бууруулан ажиллах	1	3,430.0									1	3,430.0
8	ХБХСЗХТ	АХГ-2022/235/НА-СТА-ТШЗ	ЭМДС-аас олгосон Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын дэгдэлтийн үед үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн санхүүжилтийг 28,518.8 мянган төгрөгөөр илүү зарцуулсан	Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх	1	28,518.8					1	28,518.8				
Дүн					7	105,725.8	4	64,620.4	0	0	1	28,518.8	0	0	2	12,586.6

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
1	ХБХСЗХТ	АХГ-2022/235/НА-СТА-ТШЗ	Тус байгууллага нь протез, ортопед, тусгай хэрэгслийн үйлдвэрлэл явуулдаг бөгөөд туслах үйл ажиллагаанаас өөр үйл ажиллагаа явуулаагүй тохиолдолд тогтмол зардлаас алдагдал учирвал түүнийг нөхөх төсвийн бус эх үүсвэрийг төлөвлөөгүй байна	Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газраас жил болгон сонгон шалгаруулалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст халамжийн сангаар дамжуулан олгодог тусламж үйлчилгээ олгох эрхийг тасралтгүй авч үйл ажиллагааг явуулж, алдагдалгүй байхад анхаарч, ажиллах	1								1			
2	ХБХСЗХТ	АХГ-2022/235/НА-СТА-ТШЗ	Тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс худалдан авах ажиллагааны төлөвлөгөө хугацаа хоцроож байршуулсан, өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна	Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан холбогдох ажилтанд хариуцлага тооцох	1					1		1				
Дүн					2	0	0	0	0	0	1	0	1	0		
Нийт дүн					9	105,725.8	4	64,620.4	0	0	2	28,518.8	1	0	3	12,586.6



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 131/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/235/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ЭМДС-аас олгосон Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын дэгдэлтийн үед үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн санхүүжилтийг 28,518,802.31 төгрөгөөр илүү зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй мөн санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын дэгдэлтийн үед үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн санхүүжилтээс 28,518,802.31 төгрөгийг тухайн зардалд илүү зарцуулсан зөрчлийг газарт ирүүлэх; 2022 оны 9 дүгээр сарын 30-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Хишигжаргал, ерөнхий нягтлан бодогч Г.Баасансүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АМГАЛАН АХУЙ АУДИТ  
ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

Д.АМГАЛАН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Kherig\Alban\_Shaardlaga\2022\0225\_Auditin\_2\_Gannr-174\_Docx

С0108С0417



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 132/А0150058  
АХГ-2022/235/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс худалдан авах ажиллагааны төлөвлөгөө хугацаа хоцроож байршуулсан, өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-т "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:


Дотоод, хяналт үнэлгээ, дотоод аудитын ажилтан Д.Аюушид хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ний дотор Үндэсний аудитын газарт төрийн аудитын газар ирүүлэхийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Хишигжаргалд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АМГАЛАН АХУЙ АУДИТ  
ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

Д.АМГАЛАН



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_khereg\Alban\_Shaardlaga\2022\0225\_Auditin\_2\_Gazar-125.Docx

CO108C04'9



